

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны
... дугаар сарын ... –ны өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөл, их засвар хийх болон засварлах ажлын зураг төсөл боловсруулах, улмаар зураг төслийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь байгаль, цаг уур, газар орны нөхцөлд зохицож байгаа эсэх, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдал нь зам, замын байгууламжийн норм норматив, техникийн баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төсөлд магадлал хийх ажил хамрагдана.

1.3. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажилд Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18, 4.1.20, 11 дүгээр зүйлийн 11.1.8, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 заалтыг тус тус мөрдлөг болгоно.

1.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр баригдах зам, замын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, магадлал хийхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.5. Төрийн өмчийн болон захиргааны, олон нийтийн байгууллага, иргэн, хувийн өмчийн компани нь Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төслийн баримт бичиг боловсруулах, магадлал хийлгэхдээ энэхүү журмыг үндэс болгоно.

1.6. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төсөл хийхийн өмнө шаардлагатай тохиолдолд Техник-эдийн засгийн үндэслэлийн судалгааг боловсруулна.

1.7. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төслийн баримт бичиг боловсруулах, зөвшилцөх, хяналт тавихтай холбоотой нэмэлт шаардлагыг “Авто замын тухай” хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ (Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага) чиг үүргийнхээ хүрээнд тогтоож болно.

ХОЕР. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

2.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төслийн баримт бичиг боловсруулах ажлыг нэг ба хоёр үе шаттай гэж ангилна.

2.2. Нэг үе шаттай зураг төслийг “Инженерийн нарийвчилсан зураг төсөл”, хоёр үе шаттай зураг төслийг “Техникийн зураг төсөл ба Инженерийн нарийвчилсан зураг төсөл” гэж ангилна.

2.3. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын барилгын ажлын хөрөнгө оруулагч, захиалагч байгууллага нь зураг төсөл боловсруулах үе шатыг зураг төсөл боловсруулах ажлын даалгавар болон зураг төслийн байгууллагатай байгуулах гэрээнд тодорхой тусгаж өгнө.

ГУРАВ. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ

3.1. Зураг төслийн бэлтгэл ажлыг хөрөнгө оруулагч, захиалагч талууд хариуцаж гүйцэтгэнэ.

3.2. Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын төсөлд шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн холбоод, зам ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжүүдээс санал авч болно.

3.3. Зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэлийн судалгааны ажил, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

ДӨРӨВ. ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГАА, ЗУРАГ ТӨСЛИЙН ИЖ БҮРДЭЛ

а) Техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаа

4.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэлийн судалгааны тайланд дараах иж бүрдэл багтах ба төслийн онцлогоос хамаарах бусад нэмэлт нөхцөлийг Захиалагч тавьж болно. Үүнд:

4.1.1 Инженерийн судалгааны ажил

4.1.1.1. Авто замын байр зүйн хайгуул, судалгааны ажлыг Зам, тээврийн сайдын 2016 оны 187 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн 4 дүгээр хавсралт болон холбогдох норм, дүрэм, стандартад заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

4.1.1.2. Замын барилгын материал ба түүний хайгуул, судалгааны ажлыг “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн 5 дугаар хавсралтад заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

4.1.2. Эдийн засгийн судалгаа

Эдийн засгийн судалгааны ажлыг “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн 3 дугаар хавсралтад заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

4.1.3. Байгаль орчны үнэлгээ:

Авто замыг байгаль орчны нөхцөлтэй уялдуулан төсөллөх ажлыг “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн 2 дугаар хавсралтад заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

4.1.4. Ажлын даалгаварт заасан болон шаардлагатай тохиолдолд замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийнэ.

4.1.5. Төслийн хураангуй тайлан

б) Инженерийн нарийвчилсан зураг төсөл



4.2. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын инженерийн нарийвчилсан зураг төслийн баримт бичгийн иж бүрдэл нь “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн 8 дугаар хавсралт болон холбогдох норм, дүрэм, стандартад заасны дагуу хийгдсэн байна.

ТАВ. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ, ТӨМӨР ЗАМ, АЭРОДРОМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ, ТӨСВИЙН ТООЦОО

5.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн барилга, засварын ажлын техникийн шаардлага нь Зам, тээврийн сайдын 2016 оны 186 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” болон холбогдох норм, дүрэм, стандартад нийцсэн байна.

5.2. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төслийн тайлбар бичигт төслийн танилцуулга, төсөл хэрэгжүүлэх үндэслэл болон төслийн бус нутгийн байгаль цаг уурын нөхцөл, замын чигийн сонголт, замын далан ба хучилт, хиймэл байгууламжийн тооцоо, замын хөдөлгөөний аюулгүй байдал, газар олголтын шийдвэр, дохиолол холбоо, ус хангамж, цахилгаан болон инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулахтай холбоотой хийсэн уулзалт, хурлын тэмдэглэл, албан тоот, акт, батлагдсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, магадлалын ерөнхий дүгнэлт болон холбогдох бусад мэдээллийг багтаасан байна.

5.3. Тайлбар бичгийн агуулгын талаарх дэлгэрэнгүй шаардлагыг төслийн онцлогоос хамааруулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тодорхой тусгасан байна.

5.4. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн барилга, засвар шинэчлэлтийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсөвт өртгийг тооцоходоо “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн 7 дугаар хавсралт болон холбогдох норм, дүрэм, стандартад заасны дагуу дараах байдлаар тодорхойлно.

ЗУРГАА. ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн хайгуул, зураг төслийн баримт бичгийг боловсруулахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1.1. Зураг төслийг эрх бүхий байгууллагаас баталсан ажлын даалгавар, газрын зөвшөөрөл, норм нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулсан байна.

6.1.2. Зураг төслийн байгууллага нь Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөлд техникийн шийдэл шаардсан асуудлыг холбогдох салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулна.

ДОЛОО. ЗУРАГ ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ

7.1. Захиалагч, хөрөнгө оруулагч нь зураг төслийн байгууллагатай хамтран зам, замын байгууламжийн чиглэлийг сонгосон хувилбарын талаар холбогдох төрийн

захиргааны төв байгууллага, авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, тухайн замыг дайран өнгөрч байгаа орон нутгийн засаг захиргаа, хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан байгууллагатай зөвшилцсөн акт, хурлын тэмдэглэл үйлдэж, тайлбар бичигт хавсаргана. Мөн ажлын даалгаварт зураг төслийн баримт бичгийг зөвшилцөх байгууллагыг тодорхой зааж өгнө.

7.3. Зураг төслийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын баримт бичгийг баримтлан зөвшилцнө.

НАЙМ. ЗУРАГ ТӨСЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

8.1. Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусlamжийн хөрөнгөөр санхүүжих барилгын ажлын зураг төслийг эрх бүхий гадаад улсын хуулийн этгээд боловсруулсан нөхцөлд холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу Монгол Улсын эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран баталгаажуулсан байх бөгөөд зураг төслийн баримт бичиг нь англи, монгол хэлээр байна.

8.2. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн хайгуул, зураг төслийн баримт бичгийн хуудас бүрийг зураг төслийг гүйцэтгэсэн болон шалгасан инженер, зургийн ерөнхий инженер нар гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

8.3. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нь өөрийн боловсруулсан зураг төслийн нүүр хуудсанд, тэмдэг дарж, гарын үсгээр баталгаажуулна.

ЕС. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ, ТӨМӨР ЗАМ, АЭРОДРОМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ

9.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламж, инженерийн шугам сүлжээний нарийвчилсан зураг төсөл, барилгын ажлын төсөвт өртгийн тооцоо, инженер-геологийн судалгааны тайланда магадлал хийнэ.

9.2. Хийц, технологийн онцлог, түвэгшилтэй шийдэл бүхий зам, замын байгууламж (хурдны зам, гүүрэн гаралт, олон түвшний уулзвар, хонгил зам, цахилгаан хангамж, дохиолол холбоо гэх мэт)-ийн бүрдэл хэсгийн нарийвчилсан зураг төсөлд хэсэгчлэн болон үе шаттайгаар магадлал хийж болно.

9.3. "Авто замын норм, нормативын сан"-д Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д заасны дагуу хувь хэмжээгээр тооцсон орлогыг төвлөрүүлэх ажлыг Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага хариуцан зохион байгуулна.

9.4. "Авто замын тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д заасны дагуу авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах ажлыг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ (Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага) зохион байгуулна. Үүнд:

9.4.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн ажиллах журмыг боловсруулж, хэрэгжүүлэх, экспертуудэд танилцуулах;

9.4.2. “Авто замын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5-дзаасны дагуу авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд эрх бүхий этгээдээр магадлал хийлгэж, ерөнхий дүгнэлт гарган баталгаажуулах;

9.4.3. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулах;

9.4.4. Магадлал хийлгэхээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичгийг батлагдсан хяналтын хуудасны дагуу хүлээн авч, зураг төслийн байгууллагатай магадлал хийж, гэрээг байгуулах;

9.4.5. Томоохон хэмжээний зураг төслийн ажил эсвэл хийц технологийн онцлог шийдэл бүхий зам, замын байгууламж (хурдны зам, гүүрэн гаралт, олон түвшний уулзвар, төмөр зам гэх мэт)-ийн зураг төсөлд магадлал хийх ажилд “экспертүүдийн зөвлөх-мэргэжлийн баг”-ийг зураг төслийн хайгуул, судалгааны шатанд томилон ажилуулж, зураг төслийн ажлын үе шат бүрт хяналт тавих замаар магадлалын ерөнхий дүгнэлтийг хэсэгчлэн болон үе шат бүрээр гаргуулах;

9.4.6. Энэ журмын 8.1-д заасан зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах;

9.4.7. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх экспертуудийн ажлыг дүгнэх ба магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж гаргуулан, хэрэгжүүлэх;

9.4.8. Авто зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичигт магадлал хийхтэй холбоотой маргааныг таслах үйл ажиллагаанд мэргэжлийн баг томилж, зөвлөмжийг үндэслэн шийдвэр гаргах;

9.4.9. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн дүгнэлт, магадлалын ерөнхий дүгнэлтийн маягт, дүгнэлтийг баталгаажуулах тэмдгийн загварыг батлах;

9.5. Хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, захиалгын дагуу шаардлагатай тохиолдолд магадлал хийнэ.

9.6. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх зардлын хэмжээг тухайн зураг төсөл боловсруулах ажлын гэрээний үнийн дүнгийн 8%, үүнээс магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах, хэлэлцүүлгийн болон бусад үйл ажиллагаанд зориулан 30%, магадлал хийх хуулийн этгээд, иргэний цалинд 70 хувийг тус тус хуваарилж олгоно. Магадлал хийсэн экспертуудэд олгох хөлсийг зураг төслийн бүрэлдэхүүн хэсэгт бүрт ноогдох зардлын 60 хувийг зураг төсөлд, 40 хувийг төсвийн тооцооны магадлалд хуваарилна.

9.9. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөлд магадлал хийхэд холбогдох дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдлөг болгох

ба салбарын онцлогт нийцсэн нэмэлт нөхцөлийг экспертийн ажиллах журамд тусган зохицуулна.

9.10. Магадлал хийх экспертуудийг томилохдоо Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын саналыг харгалзана.

9.11. Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл явц дор дурдсан дараалалтай байна. Үүнд:

9.11.1 Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, холбогдох норм дүрэм, стандартын шаардлагад нийцсэн тайлан, зураг төслийг хүлээн авах;

9.11.2 Зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бурд эрх бүхий эксперт, эсвэл экспертийн багаар магадлал хийлгэх;

9.11.3 Ажлын зурагт магадлал хийгдэхээс өмнө инженер-геологийн дүгнэлт магадлалаар баталгаажсан байх;

9.11.3 Шаардлагатай тохиолдолд магадлалын дүгнэлтийн дагуу холбогдох өөрчлөлт, сайжруулалтыг төслийн баримт бичигт тусгуулах;

9.11.4 Магадлалын ерөнхий дүгнэлт гаргах;

9.12. Эксперт нь зураг төсөлд магадлал хийхдээ Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д заасан шаардлагыг биелүүлэхээс гадна дараах үндсэн асуудлыг хянаж, дүгнэлт гарган холбогдох засвар өөрчлөлтийг тусгуулна.

9.12.1.авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, ажлын даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсэн байдал;

9.11.1.инженерийн шийдэл, бүтээц нь дагаж мөрдөж байгаа норм дүрэм, стандарт, инженер-геологийн дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу зохиогдсон эсэх;

9.11.2.чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;

9.11.3.хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны норм нормативын баримт бичгийн шаардлагыг баримталсан байдал;

9.11.4.магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн шаардлагыг үндэслэн техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаа, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.

9.13. Магадлалын ерөнхий дүгнэлт нь экспертийн дүгнэлтийг хавсаргаснаар хүчин төгөлдөр болно.

9.14. Магадлалын ерөнхий дүгнэлт нь доорх агуулгыг багтаасан байна. Үүнд:

- 9.14.1. авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн сонгосон байршил, техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдэл, бүтээцийн талаар тусгасан товч тодорхойлолт;

- 9.14.2. боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт;
- 9.14.3. эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн ажиллагаа, байгууламжийн нийгмийн ач холбогдол, барилгын ажлын төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт гэх мэт.

9.15. Магадлалын ерөнхий дүгнэлт нь авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн төлөвлөлт, инженерийн шийдлүүдэд өгөх мэргэжлийн үнэлгээ байна.

9.16. Шаардлагатай тохиолдолд зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх явцад холбогдох салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг ашиглана.

9.17. Зураг төсөлд магадлал хийсэн экспертийн дүгнэлт, тодорхойлолт, магадлалын ерөнхий дүгнэлтийг гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан байна.

9.18. Зураг төслийн магадлалын ажлын хугацааг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ болон магадлал хийгч эксперт эсвэл багийн ахлагч нар харилцан тохиролцно. Магадлал хийх хугацааг үндэслэлгүйгээр сунгахыг хориглоно.

9.19. Магадлал хийгдсэн зураг төслийг 2 хувь, магадлалын ерөнхий дүгнэлтийг 4 хувь хийж баталгаажуулна.

9.20. Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь зүйлд заасны дагуу авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байгууламжийн зураг төсөл зохиогчийн алдааг зураг төслийн байгууллага, зохиогч хариуцах бөгөөд зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцлага хүлээнэ.

АРАВ. ЗУРАГ ТӨСЛИЙГ ХЯНАХ, ХҮЛЭЭН АВАХ

10.1. Инженерийн нарийвчилсан зураг төслийг хянаж хүлээн авахдаа Захиалагч техник-эдийн засгийн үндэслэлийн судалгааны тайлан, зураг төслийн иж бүрдэл нь энэ журмын “Дөрөв” ба “Тавдугаар зүйл”-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянана.

АРВАН НЭГ. ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХАДГАЛАХ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ҮҮСГЭХ

11.1. Зураг төсөлтэй холбоотой баримт бичгийг Монгол Улсын Архивын тухай хууль болон бусад хууль холбогдох журмын дагуу хадгална.

11.2. Магадлал хийгдсэн инженерийн нарийвчилсан зураг төслийн эх хувийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тус бүр 4 хувь үйлдэх бөгөөд магадлалын ерөнхий дүгнэлт гаргасан эрх бүхий байгууллага нэг хувийг хадгалж, 3 хувийг захиалагч байгууллага хадгална.

-оОо-